



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/155

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолын хавсралт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн ХЭГ/701 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан “Шүүр” ажиллагааны хүрээнд томилгооны зөрчилтэй буюу хууль болон албан тушаалын тодорхойлолтын шаардлага хангаагүй томилогдсон албан хаагчдын мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэх, тэдгээрийг чөлөөлөх арга хэмжээ авахад томилох эрх бүхий албан тушаалтанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Мөнгөн-Эрдэнэ

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Б.Баярмаа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Б.Бадамнямбуусүрэн

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Х.Цэнд-Аюуш

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Ш.Дамдиндорж

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2. Хууль, албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй, томилгооны зөрчилтэй албан хаагчдын мэдээллийг сумдаас авч нэгтгэн танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Сум, багийн бодлого үйл ажиллагаа, дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн (Б.Баярмаа)-д, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг байгууллагын мэдээллийг авч нэгтгэн танилцуулахыг тус хэлтсийн Агентлаг, байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн (Б.Бадамнямбуусүрэн)-д тус албан хаагчдыг томилсон тушаал, шийдвэрийг хянан үзэж, дүн шинжилгээ хийж танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн хяналт-шинжилгээ, үнэлгээ, хууль сахиулах бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн (Х.Цэнд-Аюуш)-д, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх нэгдсэн тайланг

671 1010593

бэлтгэж, танилцуулахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн (Ш.Дамдиндорж)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.



Ш.ИДЭРБАЯСГАЛАН